



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС



2026 VII

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ





БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС

САРЫН ТАНИЛЦУУЛГА

2026 оны 7 дугаар сар

Улаанбаатар хот
2026 он

АГУУЛГА

	Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, 2022-2026 он	7
	Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, дүүргээр	7
I.	Нийгмийн даатгал, халамж	8
II.	Эрүүл мэнд	14
III.	Гэмт хэрэг	17
IV.	Төсөв	25
V.	Хэрэглээний үнэ	28
VI.	Аж үйлдвэр	33
VII.	Цаг уур, агаарын чанар, аюулт үзэгдэл, осол	38

I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.

- Сар: I, II, III, IV, V, VI, VII ... г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-IV, I-XI ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав).

II. Дараах тэмдэглэгээг ашиглав.

- гүйцэтгэл байхгүй
- * урьдчилсан гүйцэтгэл
- ** дахин их
- 1/X** дахин бага
- 0.0 маш бага тоо
- | харьцуулагдахгүй
- 0.0⁺ тэнцүү/ өөрчлөлтгүй

III. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.

IV. Та цахим хэлбэрээр үзэж буй тохиолдолд тухайн салбарын логог дарж дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгтээр MS-Excel хэлбэрээр татан авах боломжтой.

/Жич: Интернэтэд холбогдсон байх ёстой/




V. Та өөрийн гар утаснаас QR code уншуулагч аппликейшн ашиглан тухайн салбарын хавсралт хүснэгтийг MS-Excel хэлбэрээр татан авч үзэх боломжтой.

/Жич: Интернэтэд холбогдсон байх ёстой/

IV. Хэмжих нэгжийн тэмдэглэгээ

мянга	=1000
сая	=10 ⁶
тэрүм	=10 ⁹
их аяд	=10 ¹²
мян	мянга
%	хувь
мм	миллиметр
см	сантиметр
дм	дециметр
м	метр
км	километр
м ²	метр квадрат
дм ²	дециметр квадрат
км ²	километр квадрат
м ³	метр куб
га	гектар
мл	миллилитр
л	литр
г	грамм
кг	килограмм
цн	центнер
т	тонн
Вт	ватт
кВт.ц	киловатт цаг
кал	калори
ккал	килокалори
Гкал	гигакалори(=10 ⁹ калори)
с	секунд
мин	минут
мкг/м ³	микрограмм метр куб
м/с	метр секунд
ш	ширхэг
х.д.х	хэвлэлийн даралтат хуудас



МЭДЭЭЛЭЛ



МЭДЭЭЛЭЛ, ОЙ САНАМЖ

ХҮСНЭГТ 1. БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт		Хэмжих нэгж	2022 I-VII	2023 I-VII	2024 I-VII	2025 I-VII	2026 I-VII
Шинээр төрсөн хүүхэд		Хүн	2 241 ^{↓21.0}	2 302 ^{↑2.7}	1 892 ^{↓17.8}	1 826 ^{↓3.5}	1 814 ^{↓0.7}
Халдварт өвчнөөр өвчлөгчсөд		Хүн	23 608 ^{↑41.6}	1 400 ^{↓94.1}	1 278 ^{↓8.7}	3318 ^{↑159.6}	1 708 ^{↓48.5}
Бүртгэгдсэн гэмт хэрэг		Тоо	3 225 ^{↑2.51}	2 633 ^{↓18.4}	2 975 ^{↑13.0}	3 943 ^{↑32.5}	4 208 ^{↑6.7}
Хэрэглээний үнийн индекс, (сарын өөрчлөлт)		Хувь	0.6 ^{↓0.8}	-0.2 ^{↓133.3}	0.0 ^{↑100.0}	-0.1 ^{↓100.0}	0.6 ^{↑0.7}
Гадаад валютын нэрлэсэн ханш (сарын дундаж)	Доллар (АНУ)	Төгрөг	3 153 ^{↑10.7}	3 442 ^{↑9.2}	3 381 ^{↓1.8}	3 585 ^{↑6.0}	3 587 ^{↑0.1}
	Юань (БНХАУ)	Төгрөг	468 ^{↑6.4}	479 ^{↑2.4}	466 ^{↓2.7}	500 ^{↑7.3}	529 ^{↑5.8}
	Рубль (ОХУ)	Төгрөг	54 ^{↑38.5}	38 ^{↓29.6}	39 ^{↓2.6}	45 ^{↑15.4}	46 ^{↑2.2}
Дүүргийн төсвийн орлого		Тэрбум төгрөг	61.6 ^{↓3.4}	99.5 ^{↑61.5}	146.8 ^{↑47.5}	162.8 ^{↑10.9}	193.7 ^{↑19.0}
Дүүргийн төсвийн зарлага		Тэрбум төгрөг	61.1 ^{↑15.3}	91.9 ^{↑50.4}	126.2 ^{↑37.3}	163.4 ^{↑29.5}	180.3 ^{↑10.3}
Агаарын дундаж температур		°C	17.6	17.9	20.1	20.2	13.0

ХҮСНЭГТ 2. НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, дүүргээр

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2025 I-VII					2026 I-VII				
		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага	
Хүн амын нягтрал /нэг кв км-т ногдох хүн/	Тоо	357	Баянгол	8 797	Налайх	59	356	Баянгол	8 637	Налайх	59
			Чингэлтэй	1 490	Багануур	47		Чингэлтэй	1 446	Багануур	47
			Сүхбаатар	688	Багахангай	32		Сүхбаатар	677	Багахангай	30
Нялхсын нас баралт /амьд төрсөн 1000 хүүхдэд/	0\00*	15	Багануур	19	Баянгол	11	14	Багануур	25	Хан-Уул	8
			Налайх	19	Хан-Уул	9		Налайх	17	Баянгол	6
			Сүхбаатар	15	Багахангай	-		Баянзүрх	15	Багахангай	-
10 000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчлөгчсөд	0\000	165	Баянзүрх	187	Сонгино-хайрхан	115	102	Багануур	197	Баянгол	66
			Багануур	152	Багахангай	51		Баянзүрх	103	Налайх	57
			Хан-Уул	143	Налайх	48		Чингэлтэй	84	Багахангай	11
Төсвийн орлого, зарлагын харьцаа зарлага=100	тоо	80	Хан-Уул	115	Налайх	83	89	Хан-Уул	428	Багануур	77
			Сүхбаатар	110	Багахангай	83		Сүхбаатар	347	Налайх	74
			Баянзүрх	110	Багануур	23		Баянгол	323	Багахангай	23
16-аас дээш насны 10 000 хүнд ногдох Гэмт хэрэг	тоо	198	Сүхбаатар	330	Багануур	122	188	Сүхбаатар	333	Багануур	117
			Чингэлтэй	278	Налайх	69		Баянгол	250	Налайх	115
			Баянгол	230	Багахангай	45		Чингэлтэй	246	Багахангай	59



НИЙГМИЙН ДААТГАЛ

Нийгмийн даатгалын орлого өмнөх оны мөн үеэс 15.3 хувиар, нийгмийн даатгалын зарлага 14.8 хувиар тус тус өссөн байна.


2026 оны 7 дугаар сарын байдлаар нийгмийн даатгалын 5 төрлийн санд нийт 351.9 тэрбум төгрөг төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 46.7 (15.3%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

ХҮСНЭГТ 3. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, жил бүрийн 7 дугаар сард

Үзүүлэлт	2025 VII	2026 VII	<u>2026 VII</u> <u>2025 VII</u>
	сая төгрөг		хувь
Нийт орлого	305 132.1	351 870.4	15.3
Тэтгэврийн даатгалын сангийн	253 187.4	291 780.3	15.2
Тэтгэмжийн даатгалын сангийн	26 992.2	31 254.4	15.8
ҮОМШӨ ¹ -ний даатгалын сангийн	15 441.5	17 905.6	16.0
Ажилгүйдлийн даатгалын сангийн	9 511.0	10 930.1	14.9
Эрүүл мэндийн даатгалын сангийн	-	-	-
Нийт зарлага	272 164.0	312 362.3	14.8
Тэтгэврийн даатгалын сангийн	243 499.9	276 823.8	13.7
Тэтгэмжийн даатгалын сангийн	14 468.7	17 666.0	22.1
ҮОМШӨ ¹ -ний даатгалын сангийн	1 513.1	1 660.2	9.7
Ажилгүйдлийн даатгалын сангийн	12 682.3	16 212.3	27.8

¹ -Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин


ЗУРАГ 1. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, дүнд эзлэх хувиар, 2026 оны 7 дугаар сард



Даатгалын санд хуримтлуулсан нийт шимтгэлийн орлогын 82.9 хувь нь тэтгэврийн даатгалын санд, 5.1 хувь нь үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний (ҮОМШӨ) даатгалын санд, 8.9 хувь нь тэтгэмжийн даатгалын санд, 3.1 хувь нь ажилгүйдлийн даатгалын санд тус тус төвлөрчээ.

ЗУРАГ 2.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, дүнд эзлэх хувиар, 2026 оны 7 дугаар сард



Нийгмийн даатгалын сангаас 2026 оны 7 дугаар сарын байдлаар даатгуулагч иргэдэд 312.4 тэрбум төгрөгийг тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, тусламж, үйлчилгээний зардалд зарцуулжээ. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 40.2 (14.8%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Нийт зардлын 88.6 хувийг тэтгэврийн, 0.5 хувийг ҮОМШӨ-ний, 5.7 хувийг тэтгэмжийн, 5.2 хувийг ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон зардал эзэлж байна.

ХҮСНЭГТ 4.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, төрлөөр, жил бүрийн 7 дугаар сард


Үзүүлэлт	Тэтгэвэр, тэтгэмж авагчид			Олгосон тэтгэвэр, тэтгэмж		
	2025 VII	2026 VII	2026 VII 2025 VII	2025 VII	2026 VII	2026 VII 2025 VII
	тоо		хувь	сая төгрөг		хувь
Сангийн нийт зарлага	48 455	48 332	-0.3	272 164.4	312 362.3	14.8
Тэтгэврийн даатгалын сан	35 238	36 392	3.3	243 499.9	276 823.8	13.7
Өндөр насны	28 279	29 414	4.0	202 136.5	226 670.2	12.1
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэвэр	3 878	3 759	-3.1	16 649.4	19 738.8	18.6
Тэжээгчээ алдсаны	1 172	1 247	6.4	5 164.4	6 650.5	28.8
Цэргийн тэтгэвэр	1 909	1 972	3.3	19 549.6	23 749.8	21.5
Бусад зардал	-	-	-	-	14.5	-
Тэтгэмжийн даатгалын сан	10 235	8 704	-15.0	14 468.7	17 666.0	22.1
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж	7 435	5 929	-20.3	3 329.9	3 218.3	-3.4
Жирэмсэн, амаржсаны тэтгэмж	2 316	2 251	-2.8	10 150.8	12 749.5	25.6
Оршуулгын тэтгэмж	484	524	8.3	988.0	1 573.5	59.3
Бусад зардал	-	-	-	-	124.7	-
ҮОМШӨ¹-ний даатгалын сан	278	293	5.4	1 513.5	1 660.2	9.7
Тахир дутуугийн тэтгэмж	146	139	-4.8	1 119.2	1 132.7	1.2
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	25	25	-	193.2	220.3	14.0
Тэтгэмж, төлбөр	107	117	9.3	200.4	251.6	25.5
ҮОМШӨ¹-ний сувилал	-	12	-	0.7	10.7	14.3**
Бусад зардал	-	-	-	-	44.9	-
Ажилгүйдлийн даатгалын сан	2 704	2 943	8.8	12 682.3	16 212.3	27.8
Ажилгүйдлийн тэтгэмж	2 704	2 943	8.8	12 682.3	16 212.3	27.8

2026 оны 7 дугаар сарын байдлаар нийгмийн даатгалын сангаас нийт 48332 иргэнд 312362.3 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгогдсоны 36392 иргэнд 276823.8 сая төгрөгийг тэтгэврийн даатгалын сангаас, 8704 иргэнд 17666.0 сая төгрөгийг тэтгэмжийн даатгалын

сангаас, 2943 иргэнд 16212.3 сая төгрөгийг ажилгүйдлийн даатгалын сангаас, 293 иргэнд 1660.2 сая төгрөгийг үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас тус тус зарцуулсан байна.

ЗУРАГ 3.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН, тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо, жил бүрийн 7 дугаар сард



2026 оны 7 дугаар сарын байдлаар тэтгэврийн даатгалын сангаас 36392 иргэнд 276.8 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгогдсоны 80.8 хувийг өндөр настны, 10.3 хувийг хөдөлмөрийн чадвар түр алдсаны, 3.5 хувийг тэжээгчээ алдсаны, 5.4

хувийг цэргийн тэтгэвэр тус тус эзэлж байна. Тэтгэвэр авагчдийн 80.8 хувийг өндөр настны тэтгэвэр эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 1135 (4.0) иргэнээр, 24.5 (12.1%) тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.



НИЙГМИЙН ХАЛАМЖ

Нийгмийн халамжийн зарлага өмнөх оны мөн үеэс 6.2 хувиар өссөн байна.

Нийгмийн халамж нь орлого багатай, хүүхэд, өндөр настан зэрэг зорилтот бүлэгт чиглэсэн арга хэрэгсэл юм. Нийгмийн халамжийн сангаас 2026 оны 7 дугаар сарын байдлаар нийт 858.8 мянган иргэнд 103772.7 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж олгогдож, өнгөрсөн оны мөн үеэс 2690 (0.3%) иргэнээр, 6022.9 (6.2%) сая төгрөгөөр тус тус өссөн байна. Олгосон тэтгэвэр, тэтгэмжийн 67208.4 (64.8%) сая төгрөгийг хүүхдийн мөнгөн тэтгэмж, 9203.8 (8.9%) сая төгрөгийг нийгмийн

халамжийн тэтгэвэрт, 10763.6 (10.4%) сая төгрөгийг асаргааны тэтгэмж, 2840.4 (3.1%) сая төгрөгийг эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эхийн тэтгэмж, үлдсэн 11524.6 (12.8%) сая төгрөгийг онцгой тохиолдолын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, алдар цолтой ахмад настанд олгох хөнгөлөлт, тусламж, ахмад настны тэтгэмж хөнгөлөлт, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламж болон бусад тусламж тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 5.

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЛАГА, төрлөөр, жил бүрийн 7 дугаар сард

Үзүүлэлт	2025 VII		2026 VII		2026 VII 2025 VII
	Хүн	Гүйцэтгэл	Хүн	Гүйцэтгэл	
	тоо	сая төгрөг	тоо	сая төгрөг	хувь
Нийт олгогдсон тэтгэвэр, тэтгэмж	856 070	97 749.8	858 760	103 772.7	6.2
Тэтгэвэр	19 510	7 620.2	20 439	9 203.8	20.8
Асаргааны тэтгэмж	32 401	9 249.7	32 840	10 763.6	16.4
Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	61 646	3 380.0	56 730	3 217.7	-4.8
Алдарт эхийн одонгийн тусламж	12 943	3 015.9	13 432	3 115.3	3.3
Алдар цолтой ахмад настанд олгох хөнгөлөлт, тусламж	67	26.0	87	801.0	3.0**
Хүүхдийн мөнгө	673 142	67 314.2	672 084	67 208.4	-0.2
Насны хишиг	30 007	2 412.9	32 147	2 579.6	6.9
Онцгой тохиолдолын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	10	12.0	21	25.2	1.1**
Ахмад настны тэтгэмж, хөнгөлөлт	-	-	-	-	-
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламж	-	-	-	-	-
Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	14 705	3 272.7	17 334	4 832.6	47.7
Бусад	11 639	1 446.2	13 646	2 025.5	40.1

Энэ оны 7 дугаар сарын байдлаар 32147 ахмадад 2579.6 сая төгрөгийн насны хишгийг зарцуулагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 2140 (7.1%) хүн, 166.7 (6.9%) сая төгрөгөөр тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 6. АХМАД НАСТНЫ ТЭТГЭМЖ, ХӨНГӨЛӨЛТ, төрлөөр, жил бүрийн 7 дугаар сард

Үзүүлэлт	2025 VII		2026 VII		2026 VII 2025 VII
	Хүн	Гүйцэтгэл	Хүн	Гүйцэтгэл	хувь
	тоо	мянган төгрөг	тоо	мянган төгрөг	
Бүгд	5 933	1 209 392.1	6 980	1 677 075.1	38.7
Оршуулгын тэтгэмж	23	46 000.0	8	23 000.0	-50.0
Амралт, сувилал	1 577	408 225.0	1 999	513 155.0	25.7
Рашаан, сувилал	2 526	476 181.9	2987	802 088.5	68.4
Протез	1 473	187 817.2	1 468	190 193.0	1.3
Ортопед, тусгай хэрэгсэл	332	90 888.0	506	146 958.6	61.7
Ахмадын хүндэтгэл	-	-	-	-	-
Түлш болон орон сууцны үнийн хөнгөлөлт	2	280.0	12	1 680.0	5.0**

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламжийг өмнөх оны мөн үетэй харьцуулан харвал хүний тоо 481 (17.8%), олгосон тэтгэмж 117.6 (66.2%) сая төгрөгөөр тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 7. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ ХӨНГӨЛӨЛТ, ТУСЛАМЖ, төрлөөр, жил бүрийн 7 дугаар сард

Үзүүлэлт	2025 VII		2026 VII		2026 VII 2025 VII
	Хүн	Гүйцэтгэл	Хүн	Гүйцэтгэл	хувь
	тоо	мянган төгрөг	тоо	мянган төгрөг	
Бүгд	2 706	177 667.3	3 187	295 217.2	66.2
Харилцаа, холбооны зардлын хөнгөлөлт	2 318	46 479.0	2 319	46 289.7	-0.4
Оршуулгын тэтгэмж	25	50 000.0	12	36 000.0	-28.0
Цэцэрлэг сургуулийн унааны зардал	24	4 800.0	20	4 000.0	-16.7
Рашаан сувилал	94	25 149.3	81	33 039.9	31.4
Протез	69	11 905.0	113	23 250.0	95.3
Ортопед тусгай хэрэгсэл	116	30 934.0	601	146 897.6	3.7**
Түлш болон орон сууцны үнийн хөнгөлөлт	60	8 400.0	41	5 740.0	-31.7
Бусад	-	-	-	-	-

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөнгөлөлт, тусламж авсан нийт хүний дийлэнх буюу 72.8 хувийг харилцааны холбооны зардлын хөнгөлөлт авсан иргэд эзэлж байгаа боловч

олгосон тэтгэмж нь 15.7 хувь байна. Харин ортопед, тусгай хэрэгслийн хөнгөлөлт, тусламж авсан иргэдийн мөнгөн дүн 49.8 буюу хамгийн их хувийг эзэлж байна.

Ойлголт, тодорхойлолт:

Нийгмийн даатгал: Иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

Нийгмийн даатгалын сан: Ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Даатгуулагч: Хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

Тэтгэвэр: Даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.

Тэтгэмж: Хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах, жирэмсний, амаржсаны чөлөө эдлэх, ажилгүй болох тохиолдолд даатгуулагч өөрт нь, даатгуулагч нас барах тохиолдолд гэр бүлд нь хууль заасан болзол, нөхцөлийн дагуу нийгмийн даатгалын сангаас тодорхой хугацаанд буюу нэг удаа олгох мөнгөн олговор байна.

Нийгмийн халамж: Эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

Байнгын асаргаа шаардлагатай иргэн: Бусдын тусалцаагүйгээр өдөр тутмын үйлдлээ бие даан гүйцэтгэх чадваргүй, эсхүл оюуны хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн хүнд хэлбэрийн эмгэгтэй хүнийг хэлнэ.

Бүтэн өнчин хүүхэд: Эцэг, эх нь тогтоогдоогүй, эсхүл эцэг, эх нь хоёул нас барсан, сураггүй алга болсон, эрх зүйн чадамжгүй, эцэг, эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, түүнчлэн эцэг тодорхойгүйн улмаас эхтэйгээ амьдарч байгаад эх нь нас барсан, гэр бүл салсны улмаас асрамждаа авсан эх/эцэг/ нь нас барсан 18 хүртэлх насны хүүхдийг хэлнэ.

Өрх толгойлсон эх /эцэг/: Нөхөр, эхнэрийн аль нэг нь нас барсан, эсхүл сураггүй алга болсон нь шүүхээр тогтоогдсон, гэрлэлтээ цуцлуулсан, эцэг, эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, гэрлэж байгаагүй боловч төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхэдтэй ганц бие эх /эцэг/-ийг хэлнэ.

Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ: Асран хамгаалах, харгалзан дэмжих төрөл, садангүй бөгөөд бие даан амьдрах чадваргүй, ганц бие, байнгын эмчилгээ, асаргаа шаардагдах ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэн, түүнчлэн хүнд нөхцөлд байгаа хүүхдийг байрлуулан хоол, хувцас, эмнэлэг, соёл, ахуй, сэтгэл зүй, асаргаа сувилахуйн үйлчилгээ үзүүлэх, тэдний амьдралын хэвийн нөхцөлийг бүрдүүлэх, хууль ёсны эрх ашгийг нь хууль тогтоомжид заасны дагуу хамгаалах үйл ажиллагаа хэлнэ.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ: Иргэн, аж ахуйн нэгж, төр болон төрийн бус байгууллагын оролцоотойгоор өрх, иргэнд дэмжлэг тусалцаа, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг хэлнэ.

Эх үүсвэр:

Дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн сарын мэдээ

Дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн сарын мэдээ



ЭРҮҮЛ МЭНД

2026 оны 7 сард 1 790 эх амаржсан нь өмнөх оны мөн үеэс 20 (1.1%) төрөлтөөр буурсан байна.

Дүүргийн хэмжээнд 2026 оны эхний 7 сард 1790 эх амаржиж, 1814 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс амаржсан эх 20 (1.1%), мэндэлсэн хүүхэд өмнөх оны мөн үеэс 12 (0.7%) хүүхдээр

тус тус буурсан байна. Амьгүй төрөлтийн 8 тохиолдол бүртгэгджээ. Нийт амаржсан эхчүүдийн дунд гэртээ төрсөн тохиолдол бүртгэгдээгүй байна.

ХҮСНЭГТ 8.

ТӨРСӨН ХҮҮХЭД, ЭХ ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, жил бүрийн эхний 7 сард


Үзүүлэлт	2024 I-VII	2025 I-VII	2026 I-VII	Өөрчлөлт %
Амаржсан эхийн тоо	1 874	1 810	1 790	-1.1
Гэрийн төрөлт	1	2	-	-
Хяналтгүй төрөлт	5	5	7	40.0
Амьгүй төрөлт	5	4	8	100.0
Амьд төрсөн хүүхэд	1 892	1 826	1 814	-0.7
Эхийн эндэгдэл	-	1	-	-
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	22	20	10	-50.0
1-5 настай хүүхдийн эндэгдэл	3	1	3	3.0**
Нас барсан хүн	556	544	553	1.7

2026 оны эхний 7 сард 0-1 хүртэл насандаа эндсэн 10 тохиолдол бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 10 (50.0%)-аар буурсан байгаа бол 1-5 настай хүүхдийн эндэгдэл 3 бүртгэгдсэн байна.

Дүүргийн хэмжээнд нас баралт 553 бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 9 (1.7%) хүнээр өссөн байна.

ЗУРАГ 4.

ХАЛДВАРТ ӨВЧИН, сараар



Дүүрэгт 2026 оны эхний 7 сарын байдлаар 1708 халдварт өвчин бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1610 (48.5%) тохиолдлоор буурсан байна. Цочмог халдварт өвчний 26.9 хувийг салхин

цэцэг, 3.3 хувийг улаан эсэргэнэ, 35.0 хувийг энтеровируст цэврүүт фарингит, 8.3 хувийг улаан бурхан, 26.5 хувийг цусан суулга, ёлом, гепатит, сальмонеллёз зэрэг өвчин тус тус эзлээд байна.

ХҮСНЭГТ 9. ХАЛДВАРТ ӨВЧИН, жил бүрийн эхний 7 сард

Төрөл	Хэмжих нэгж	2024 I-VII	2025 I-VII	2026 I-VII	Өөрчлөлт	
					тоо/нэгж хувь	хувь
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн, бүгд	тоо	1 278	3 318	1 708	-1 610	-48.5
	10000 хүнд	51.1	129.5	66.4	-63.1	
Вируст гепатит	тоо	15	12	7	-5	-41.7
	10000 хүнд	0.5	-	-	-	
Цусан суулга	тоо	77	64	42	-22	-34.4
	10000 хүнд	3.1	2.5	1.6	-0.9	
Сальмонеллөз	тоо	17	33	25	-8	24.2
	10000 хүнд	0.7	1.3	1.0	-0.3	
Халдварын гаралтай гастроэнтерит ба суулга өвчин	тоо	-	9	4	-5	-55.6
	10000 хүнд	-	0.4	0.2	-0.2	
Хоолны хордлого	тоо	12	44	16	-28	-63.6
	10000 хүнд	0.5	1.7	0.6	-1.1	
Энтервируст халдвар тодорхойгүй/В34.1/	тоо	-	140	76	-64	-45.7
	10000 хүнд	-	5.5	3.0	-2.5	
Салхинцэцэг	тоо	459	590	373	-217	-36.8
	10000 хүнд	18.4	23	14.5	-8.5	
Гахай хавдар	тоо	28	7	9	2	-28.6
	10000 хүнд	1.1	0.3	0.4	0.1	
Улаан эсэргэнэ	тоо	56	64	46	-18	-28.1
	10000 хүнд	2.24	2.5	1.8	-0.7	
Ёлом	тоо	6	17	7	-10	-58.8
	10000 хүнд	0.2	0.7	0.3	-0.4	
Бруцеллөз	тоо	-	-	-	-	-
	10000 хүнд	-	-	-	-	
Менингококкт халдвар	тоо	-	1	2	1	100.0
	10000 хүнд	-	-	0.1	0.1	
Энтервируст тууралттай цэврүүт фарингит	тоо	136	98	486	388	4.0**
	10000 хүнд	5.4	3.8	18.9	15.1	
Эритема	тоо	1	140	35	-105	-75.0
	10000 хүнд	-	5.5	1.4	-4.1	
Улаан бурхан	тоо	-	1 547	115	-1 432	-92.6
	10000 хүнд	-	60.4	4.5	-55.9	
Спирохетээр сэдээгдсэн бусад халдвар/А69	тоо	-	-	1	1	-
	10000 хүнд	-	-	-	-	-
Хачигт рикеттсиоз	тоо	1	1	9	8	9.0**
	10000 хүнд	-	-	0.4	0.4	-
Бусад халдварт өвчин	тоо	-	146	134	-12	8.2
	10000 хүнд	-	5.7	5.2	-0.5	
Хачгаар дамжих вируст энцефалит, тодорхойгүй А84.9	тоо	-	-	1	1	-
	10000 хүнд	-	-	-	-	-
Тэмбүү	тоо	237	164	146	-18	-11.0
	10000 хүнд	9.5	6.4	5.7	-0.7	
Гонококкт халдвар	тоо	79	85	37	-48	-56.5
	10000 хүнд	3.2	3.3	1.4	-1.9	

Төрөл	Хэмжих нэгж	2024 I-VII	2025 I-VII	2026 I-VII	Өөрчлөлт	
					тоо/нэгж хувь	хувь
Трихомониаз	тоо	47	46	46	-	-
	10000 хүнд	1.9	1.8	1.8	-	-
Сүрьеэ	тоо	107	110	90	-20	-18.2
	10000 хүнд	4.1	4.3	3.5	-0.8	
ДОХ	тоо	-	-	-	-	-
	10000 хүнд	-	-	-	-	
Мөөгөнцөр	тоо	-	-	1	1	-
	10000 хүнд	-	-	-	-	

Өнгөрсөн оны мөн үеэс гоногкоккт халдвар 48 (56.5%) тохиолдлоор буурсан эерэг үзүүлэлттэй байна. 10.0 мянган хүн тутмын 5.7 нь тэмбүү өвчнөөр өвчилж байна.

Баянгол дүүрэгт 2026 оны эхний 7 сард 1388 хүн цочмог халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 1525 (52.4%) хүнээр буурсан байна.

Ойлголт, тодорхойлолт:

Амьд төрөлт: Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байсан зэргийг (хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн жилд 0-28 хоногтой эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эхийн эндэгдлийн харьцаа (100000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд эндсэн эхийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эндсэн эх: Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэнийг хамруулна.

Эх үүсвэр:

Дүүргийн Эрүүл мэндийн төвийн сарын мэдээ



ГЭМТ ХЭРЭГ

Баянгол дүүрэгт 4208 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 265 (6.7%) хэргээр өссөн байна.

2026 оны 7 сард 4208 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 265 (6.7%) хэргээр өсөж, гэмт хэргийн илрүүлэлт 43.9 хувьтай байгаа нь 14.6 нэгж хувиар өссөн байна. Гэмт хэргийн улмаас 3862 иргэн хохирч, 66.5 сая төгрөгийн хохирол учруулснаас 12.0 сая (18.0%) төгрөгийг нөхөн төлүүлжээ. Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 47.6 хувийг залилан, 12.8 хувийг хүний

эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 14.3 хувийг хулгайн, 3.0 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг, 1.0 хувийг хүний амьд явах эрхийн эсрэг, 1.9 хувийг дээрмийн, 1.0 хувийг хүчин, 0.2 хувийг хүнийг санаатай алах, 18.2 хувийг бусад гэмт хэрэг тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 10.


БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, жил бүрийн 7 дугаар сард

Төрөл	Гэмт хэргийн тоо			Өөрчлөлт	
	2024 VII	2025 VII	2026 VII	Тоо	Хувь
Нийт гэмт хэрэг	2 975	3 943	4 208	265	6.7
Хүнийг санаатай алах	14	8	10	2	25.0
Хүний амьд явах эрхийн эсрэг	50	64	40	-24	-37.5
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	540	594	539	-55	-9.3
Хүчиндэх	26	46	41	-5	-10.9
Хулгайлах	617	700	603	-97	-13.9
Дээрэмдэх	73	107	82	-25	-23.4
Залилан	1 041	1 789	2 004	215	12.0
Танхайрах	-	2	2	-	-
ХАБТХАЖЭ	104	110	125	15	13.6
Бусад гэмт хэрэг	510	523	762	239	45.7

Өнгөрсөн оны мөн үеэс дүүргийн нутаг дэвсгэрт гарсан гэмт хэрэг өссөн сөрөг үзүүлэлтэд хүнийг санаатай алах 2 (25.0%), залилан 215 (12.0%), хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг 15 (13.6%), бусад гэмт хэрэг 239 (45.7%) нэгжээр

тус тус өссөн нь голлон нөлөөлжээ. Харин хүний амьд явах эрхийн эсрэг 24 (37.5%), хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 55 (9.3%), хүчин 5 (10.9%), хулгайлах 97 (13.9%), дээрэмдэх 25 (23.4%) нэгж хэргээр буурсан эерэг үзүүлэлттэй байна.

ЗУРАГ 5.

БҮРТГЭГДСЭН ХУЛГАЙН ГЭМТ ХЭРЭГ, төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2026 оны 7 дугаар сард

Бүртгэгдсэн хулгайн гэмт хэргийн 476 (78.9%) нь иргэдийн өмчийн, 91 (15.1%) нь халаасны, 11 (1.8%) нь авто тээврийн хэрэгсэл, 25 (4.2%) нь бусад хулгайн гэмт хэрэг тус тус эзэлж байна. Харин өнгөрсөн оны мөн үеэс авто тээврийн хэрэгслийн хулгай хамгийн их буюу 56.0 хувь буурсан байна.

Монгол Улсын Эрүүгийн тухай хууль шинэчлэгдэн батлагдаж, 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор гэмт хэргийг хөнгөн, хүнд гэж ангилдаг болсон. 2026 оны 7 дугаар сарын байдлаар бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 3968 (94.3%) нь хөнгөн хэрэг, 240 (5.7%) нь хүнд хэрэг байна.


ХҮСНЭГТ 11.

БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, төрлөөр, хэлтсээр, 2026 оны 7 дугаар сард

Төрөл		Бүгд		
		Цагдаагийн I хэлтэс		Цагдаагийн II хэлтэс
		Тоо		
Нийт гэмт хэрэг		4 208	2 350	1 858
Хэргийн ангилал	Хөнгөн	3 968	2 218	1 750
	Хүнд	240	132	108
	Хүнийг алах	10	7	3
	Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	40	22	18
	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	539	288	251
	Хүчиндэх	41	24	17
	Хулгайлах	603	321	282
Гэмт хэргийн төрөл	o Иргэдийн өмчийн	476	253	223
	o Авто тээврийн хэрэгслийн	11	8	3
	o Халаасны	91	49	42
	o Бусад	25	11	14
	Дээрэмдэх	82	46	36
	Залилах	2 004	1 050	954
	Танхайрах	2	2	-
ХАБТХАЖЭ ²		125	67	58
Бусад		762	523	239


Нийт бүртгэгдсэн 4208 гэмт хэргээс 2350 (55.8%) нь цагдаагийн I хэлтэст, 1858 (44.2%) нь цагдаагийн II хэлтэст гарч, өнгөрсөн оны мөн үеэс I хэлтэст 75 (3.3%), II хэлтэст 190 (11.4%)

хэргээр тус тус өссөн сөрөг үзүүлэлттэй байна. Нийт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн 205 (4.9%) нь согтуугаар, 232 (5.5%) нь бүлэглэн, 829 (19.7%) нь эмэгтэй хүн оролцсон гэмт хэрэг байна.

ЗУРАГ 6. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, үйлдэгдсэн цаг, гарагаар, жил бүрийн 7 дугаар сард

Энэ оны 7 дугаар сарын байдлаар лхагва, мягмар, пүрэв гаригт хамгийн их буюу 1896 (45.1%) гэмт хэрэг бүртгэгдсэн байна. Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн хамгийн их үйлдэгдсэн нь мягмар гарагийн 06:00-14:00 цагийн хооронд байна. Дүүргийн хэмжээнд 2026

оны 7 дугаар сарын байдлаар гэмт хэрэг хамгийн их үйлдэгдсэн газар болох гэр, орон сууцанд 1649 (39.2%) хэрэг, гудамж талбайд 1242 (29.5%) хэрэг, олон нийтийн газарт 678 (16.1%) хэрэг, бусад үйлдэгдсэн газар 639 (15.2%) тус тус бүртгэгдсэн байна.

ЗУРАГ 7. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, хороогоор, жил бүрийн 7 дугаар сард

Гэмт хэргийн гаралтыг хороо тус бүрээр өмнөх оны мөн үетэй харьцуулахад 34-р хороо 50 (57.5) хувиар буурсан эерэг үзүүлэлттэй байгаа бол бусад хороодод 1.0 хувиас 1.1 дахин их хувиар өссөн сөрөг үзүүлэлттэй байна.

Дүүргийн долоодугаар хорооны нутаг дэвсгэрт 485 (54.0%) гэмт хэргийн бүртгэгдсэн нь хамгийн их байсан бол хамгийн бага нь 27, 28, 30, 32, 34 дүгээр хороодод бүртгэгдсэн байна.

ХҮСНЭГТ 12.

НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, хороо, төрлөөр, 2026 оны 7 дугаар сард

Хороо	Нийт	Хүн амь	Хүнийг амиа хорлох нөхцөл	Хүний эрүүл мэндийн халдашгүй	Хүчин	Хулгай	Дээрэм	Залилан	Танхайрах	ХАБТХАЖЭ ²	Бусад
	Тоо										
Бүгд	4 208	10	40	539	41	603	82	2 004	2	125	762
I хороо	323	-	1	13	2	20	4	82	-	4	197
II хороо	380	2	3	12	-	40	4	270	1	10	38
III хороо	189	-	-	14	-	13	1	117	-	4	40
IV хороо	119	1	2	17	1	22	2	31	-	6	37
V хороо	124	-	4	20	2	36	2	33	-	9	18
VI хороо	144	-	-	20	-	21	2	70	-	9	22
VII хороо	485	-	-	21	-	14	2	426	-	4	18
VIII хороо	93	1	1	30	1	14	3	28	-	2	13
IX хороо	86	-	2	19	2	26	3	22	-	2	10
X хороо	61	-	-	9	1	10	3	20	-	1	17
XI хороо	221	-	3	18	2	29	3	124	-	8	34
XII хороо	85	-	3	19	2	11	2	24	-	3	21
XIII хороо	160	-	2	29	-	27	5	76	-	6	15
XIV хороо	139	-	-	33	1	33	5	36	-	5	26
XV хороо	71	-	-	11	1	10	1	31	-	3	14
XVI хороо	201	1	5	25	-	27	4	112	1	3	23
XVII хороо	130	1	1	29	4	19	4	43	-	3	26
XVIII хороо	118	-	-	15	2	16	2	48	-	5	30
XIX хороо	85	1	1	17	-	20	2	30	-	4	10
XX хороо	139	1	2	18	2	19	3	61	-	8	25
XXI хороо	43	-	-	5	2	5	1	21	-	1	8
XXII хороо	69	-	1	21	6	9	5	16	-	4	7
XXIII хороо	46	1	1	11	3	5	2	10	-	7	6
XXIV хороо	101	-	1	15	-	27	1	43	-	-	14
XXV хороо	61	-	2	10	2	10	-	21	-	2	14
XXVI хороо	108	1	1	16	1	21	-	43	-	3	22
XXVII хороо	39	-	1	7	-	6	-	18	-	1	6
XXVIII хороо	41	-	-	3	-	11	2	22	-	-	3
XXIX хороо	145	-	2	21	1	28	5	65	-	3	20
XXX хороо	21	-	-	3	-	7	-	8	-	1	2


Хороо	Нийт	Хүн амь	Хүнийг амиа хорлох нөхцөл	Хүний эрүүл мэндийн халдашгүй	Хүчин	Хулгай	Дээрэм	Залилан	Танхайрах	ХАБТХАЖЭ ²	Бусад
	тоо										
XXXI хороо	55	-	-	13	-	13	3	18	-	2	6
XXXII хороо	42	-	-	6	3	13	-	14	-	1	5
XXXIII хороо	47	-	-	8	-	12	6	14	-	1	6
XXXIV хороо	37	-	1	11	-	9	-	7	-	-	9

Бүртгэгдсэн зөрчил:

Дүүргийн нутаг дэвсгэрт энэ оны 7 дугаар сарын байдлаар 22052 зөрчил илрүүлсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 1187 (5.1%) хэргээр буурч, зөрчил гаргасан 21892 иргэн, хуулийн

этгээдийг 815.6 сая төгрөгөөр торгосон бол 291 хүнийг “Зөрчлийн тухай” хуулиар баривчилжээ.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 44.8 хувь нь I хэлтэст, 55.2 хувь нь II хэлтэс тус тус бүртгэгдсэн байна.

ЗУРАГ 8. БҮРТГЭГДСЭН ЗӨРЧИЛ, хэлтсээр, жил бүрийн 7 дугаар сард

Нийт илрүүлсэн зөрчлийн шийдвэрлэлт, илрүүлэлтийн хувийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад I хэлтэс 18 (0.2%) хэргээр өссөн бол, II хэлтэс 1205 (8.7%) хэргээр буурсан байна.

Нийт илрүүлсэн зөрчлийг нийслэлийн 9 дүүргийн хэлтсүүдтэй харьцуулахад Баянгол дүүргийн цагдаагийн II хэлтэс гуравдугаарт, I хэлтэс наймдугаарт эрэмбэлэгдэж байна.

Гэмт хэрэг


Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл:

Дүүргийн хэмжээнд 2026 оны 7 дугаар сарын байдлаар 18550 гомдол, мэдээллийг хүлээн авч шалгаснаас 8294 (44.7%) нь гэмт хэргийн

шинжтэй, 10256 (55.3%) нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл ирсэн байна.

ЗУРАГ 9.

БҮРТГЭГДСЭН ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ, шалган шийдвэрлэсэн байдлаар, 2026 оны 7 дугаар сард



Гэмт хэргийн шинжтэй 8294 гомдол мэдээллийн 7633 (92.0%) хэргийг шийдвэрлэснээс 2933 (38.4%) нь хэрэг бүртгэлийн хэрэг нээсэн, 4493 (58.9%) нь хэрэг нээхээс татгалзсан, 207 (2.7%) нь харъяаллын дагуу шилжүүлэн хэргийг шийдвэрлэсэн байна. Нийт шийдвэрлэсэн 7633 гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг 5 хоногт 1145 (15.1%) хэргийг, 6-19 хоногт 6479 (84.9%) хэргийг


тус тус шийдвэрлэн ажиллажээ. Нийт шалган шийдвэрлэгдсэн зөрчлийн шинжтэй 10256 гомдол мэдээллийн 10188 (99.3%) хэргийг шийдвэрлэснээс 5239 (51.4%) хэрэгт зөрчлийн хэрэг нээсэн болон хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн, 4875 (47.9%) хэргийг нь зөрчлийн хэрэг нээхээс татгалзсан, 56 (0.5%) бүртгэлийн хэрэг нээсэн, 18 (0.2%) хэргийг нь харъяаллын дагуу шилжүүлсэн байна.

Зам тээврийн осол, зөрчил:

2026 оны 7 дугаар сарын байдлаар дүүргийн хэмжээнд нийт ослын шинжтэй 12230 дуудлага бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 537 (4.2%) дуудлагаар буурсан эерэг үзүүлэлттэй байна.

ЗУРАГ 10.

БҮРТГЭГДСЭН ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, дүүргээр, 2026 оны 7 дугаар сард



Улаанбаатар хотод нийтдээ 8783 зам тээврийн осол бүртгэгдсний 2371 (27.0%) нь Баянзүрх, 1497 (17.0%) нь Хан-Уул, 1654 (18.8%) нь Сонгинохайрхан, 1367 (15.6%) нь Баянгол, 1164 (13.3%) нь Сүхбаатар, 710 (8.1%) нь Чингэлтэй, 11 (0.1%) нь Налайх, 1 (0.01%) нь Багахангай, 5 (0.1%) нь Багануур дүүргүүдэд байна.

Бүртгэгдсэн ослыг дүүргийн хэмжээнд өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулан авч үзвэл 10.2 хувиар, эд материалын хохиролтой осол 9.9 хувиар буурсан эерэг үзүүлэлттэй байна.

ХҮСНЭГТ 13.

БҮРТГЭГДСЭН ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, төрлөөр, жил бүрийн эхний 7 дугаар сарын байдлаар

Үзүүлэлт	2024 I-VII	2025 I-VII	2026 I-VII	2026 I-VII 2025 I-VII
	Тоо			хувь
Нийт	2 257	1 952	1 753	-10.2
Эд материалын хохиролтой осол	2 013	1 756	1 582	-9.9
Хүн гэмтсэн осол	244	196	171	-12.8

Нийт зам тээврийн осол 1753 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 199 (10.2%) буурсан эерэг өөрчлөлттэй байна. Нийт бүртгэгдсэн зам тээврийн ослын 174 (9.9%) нь эд материалын хохиролтой осол, хүн гэмтсэн осол 25 (12.8%) тус тус буурсан байна. 2026 оны 7 дугаар сарын

байдлаар зам тээврийн ослын улмаас нийт 186 хүн бэртэж үүнээс хүн нас барсан 9 тохиолдол бүртгэгдсэн байна. Зам тээврийн ослын улмаас бэртсэн иргэдийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт хохирсон иргэн 19 (8.9%) буурсан эерэг өөрчлөлттэй байна.


ХҮСНЭГТ 14.

ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН УЛМААС БЭРТСЭН ИРГЭД, төрлөөр, жил бүрийн эхний 7 дугаар сарын байдлаар


Үзүүлэлт	2024 I-VII	2025 I-VII	2026 I-VII	2026 I-VII 2025 I-VII
	Тоо			хувь
Нийт хохирсон иргэд	271	214	195	-8.9
Хүн гэмтсэн	269	212	186	-12.3
Хүн нас барсан	2	2	9	3.5**

ЗУРАГ 11.

БҮРТГЭГДСЭН ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, хэлбэрээр, тээврийн хэрэгслийн төрлөөр, дүнд эзлэх хувь, 2026 оны эхний 7 дугаар сарын байдлаар



Нийт гэмтсэн хүний 108 (57.1%) хувийг явган зорчигч, 25 (13.2%) хувийг зорчигч, 44 (23.3%) жолооч, 12 (6.4%) хувийг дугуйтай хүн эзэлж байна. Бүртгэгдсэн зам тээврийн ослын 1527 (87.1%) нь мөргөлдсөн, 123 (7.0%) нь явган хүн дайрсан, 78 (4.4%) нь үл хөдлөх зүйл мөргөсөн, 21 (1.5%) нь бусад байна. Зам тээврийн ослыг тээврийн хэрэгслийн төрлөөр нь 1439



(82.1%) нь суудлын, 139 (7.9%) нь ачааны, 58 (3.3%) нь автобус, 9 (0.5%) микроавтобус, 43 (2.5%) нь мотоцикл, 18 (1.0%) нь унадаг дугуй, 47 (2.7%) нь бусад эзэлж байна. Энэ оны 7 дугаар сарын байдлаар бүртгэгдсэн зам тээврийн ослын 2626 (70.3%) хэргийг даатгалд шилжүүлж, 958 (25.7%) хэрэгт акт тавьж, 149 (4.0%) хэргийн өргөдлийг хүлээн авсан байна.

Ойлголт, тодорхойлолт:

Гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг: Тухайн хугацаанд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоог 16, түүнээс дээш насны хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10000-аар үржүүлж тооцно.

Хохирогч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

Гэмт хэргийн хохирол: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Яллагдагч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.

Эх үүсвэр:
Дүүргийн Цагдаагийн I, II хэлтсийн сарын мэдээ



ДҮҮРГИЙН ТӨСӨВ

Баянгол дүүргийн төсвийн нийт орлого 193.7 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 31.1 тэрбум төгрөгөөр дутуу бүрджээ.

Дүүргийн төсвийн нийт орлого 2026 оны эхний 7 сарын байдлаар 193687.6 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 31145.4 (13.9%) тэрбум төгрөгөөр дутуу бүрджээ. Төсвийн нийт орлогын 96.1 хувийг татварын орлого (орлогын албан татвар, хөрөнгийн татвар, бусад татвар, төлбөр,

хураамж), 3.9 хувийг татварын бус орлого тус тус эзэлж байна.

Татварын орлогын дүнд хувь хүний орлогын албан татварын шилжүүлэг хамгийн өндөр буюу 168949.4 (90.8%) тэрбум төгрөгийг эзэлж байна.

ХҮСНЭГТ 15. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, 2026 ОНЫ ЭХНИЙ 7 САРД

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт
	сая төгрөг		хувь
Нийт орлого	224 833.0	193 687.6	-13.9
1.Татварын орлого	220 735.6	186 123.8	-15.7
1.1 Орлогын албан татвар	204 420.0	168 949.4	-17.4
Хувь хүний орлогын албан татвар	204 420.0	168 949.4	-17.4
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал	164 715.0	127 159.4	-22.8
Үйл ажиллагааны орлого	2 500.0	3 099.3	24.0
Хөрөнгийн орлого	9 625.0	9 998.9	3.9
Хөрөнгө борлуулсны орлого	9 380.0	8 246.7	-12.1
Шууд бус орлого	18 200.0	20 445.1	12.3
1.2 Хөрөнгийн татвар	9 070.6	9 791.9	8.0
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	9 030.0	9 756.3	8.0
Бууны албан татвар	40.6	35.4	-12.8
Малд ногдуулах албан татвар	-	0.2	-
1.3 Бусад татвар, төлбөр, хураамж	7 245.0	7 382.5	1.9
Бусад нийтлэг татвар, төлбөр, хураамж	3 463.0	2 915.1	-15.8
Улсын тэмдэгтийн хураамж	551.0	212.8	-61.4
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	-	52.7	-
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	2 912	2 649.6	-9.0
Газрын төлбөр	3 782.0	4 463.7	18.0
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	-	3.7	-
2. Татварын бус орлого	4 097.4	7 563.9	84.6
2.1 Нийтлэг татварын бус орлого	3 570.3	6 912.7	93.6
Торгуулийн орлого	2 310	6 150.1	2.7**
Төсөвт байгууллагын өөрийн орлого /үндсэн/	1 248.5	744.4	-40.4
